



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

**Хариуцлагатай эргүүл, жижүүр
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.1.3, газрын хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.1, 2.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийтээр амрах амралтын өдөр буюу Цагаан сарын баярын өдрүүдэд Нийслэлийн Засаг захиргааны байр, Нутгийн захиргааны төв цогцолбор, дэд төвүүдэд хариуцлагатай эргүүл, жижүүрээр ажиллах албан хаагчдын нэрсийг нэгдүгээр, дундын жижүүрийн хуваарийг хоёрдугаар, цахилгаанчны ажиллах хуваарийг гуравдугаар, слесариудын хуваарийг дөрөвдүгээр, операторын хуваарийг тавдугаар, лифтчины хуваарийг зургаадугаар, харуул жижүүрийн хуваарийг долоодугаар, эргүүлээр ажиллах инженерийн хуваарийг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нийслэлийн Засаг захиргааны байр, Нутгийн захиргааны төв цогцолбор, дэд төвүүдийн цахилгаан, инженерийн байгууламжийн хэвийн жигд ажиллагааг хангаж, гал усны аюулаас урьдчилан сэргийлж, харуул хамгаалалтын ажилтнуудтай хамтран ажиллаж, гарсан зөрчил, доголдлыг шуурхай шийдвэрлэн, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч ажиллахыг хариуцлагатай эргүүл, жижүүрээр ажиллах албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн талаар газрын удирдлагад танилцуулж ажиллахыг халаалт, агаар сэлгэлтийн инженер /Б.Доржбалжир/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

C:\Users\Desktop\A tushaal.docx

1150500015